

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ХҮҮХДИЙН ТӨВ СУВИЛЛЫН
ЗАХИРАЛ Д.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.27 № 06/638
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн төв сувиллын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүүхдийн төв сувиллын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам зааврын дагуу үнэн зөв, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүүхдийн төв сувиллын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1. ОРШИЛ

Хүүхдийн төв сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хүүхдийн төв сувиллын захирал Д.Оюунцэцэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчид төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 125 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт-д нийцүүлэн харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийг бэлтгэж ажиллах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн төв сувиллын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүүхдийн төв сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Хүлэгтхүннү аудит ХХК-ийн аудитор Ц.Алтанзул, аудитын менежер Э.Энхзаяа, аудиторын туслах Г.Мишээлт нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хүүхдийн төв сувилал нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг УАГ-ын Санхүүгийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 26 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Үндэсний аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүүхдийн төв сувиллын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Үйлчлүүлэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, чанартай, аюулгүй байдлыг хангасан, мэргэжлийн тусламж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй цаг хугацаанд нь үзүүлэх оршино.

Хүүхдийн төв сувиллын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Үндсэн чиглэл: Хүүхдийн төв сувилал нь дутуу болон бага жинтэй нярай, өсөлт, бойжилтын хоцрогдол, хоол тэжээлийн эмгэг дуталтай 3 хүртэлх насны хүүхдийг хүлээн авч, эмчлэх, сувилах, торниулах, сэргээн засах, чийрэгжүүлэх, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт явуулах, судалгаа шинжилгээ хийдэг.

Үйл ажиллагаа: Хүүхдийн төв сувилал нь улсын хэмжээнд 0-3 насны:

- 3 ихэр хүүхдийг,
- Хагас болон бүтэн өнчин хүүхдийг,
- Дутуу нярай, эмгэгтэй нярай хүүхдийг /шарлалт, тархины цусан хангамжийн дуталтай/,
- Сульдаа, тураал, цус багадалттай 3 хүртэлх насны хүүхдийг,
- Амьжиргааны түвшингээс доогуурх орлоготой орон гэргүй хүмүүсийн хоол тэжээлийн эмгэг дуталтай 3 хүртэлх насны хүүхдийг,
- 0-3 насны гэр бүлдээ хаягдсан олдмол хүүхдийг хүлээн авч сувилж эмчлэх, асарч торниулах, сэргээн засах, чийрэгжүүлэх тусламж үйлчилгээг үзүүлдэг.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль шинэчлэгдсэн,
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 25 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоосон,
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 276 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоосон,
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоосон бөгөөд тайланд жилд эдгээр шинэчилсэн тогтоол, хуулийг Хүүхдийн төв сувилал нь үйл ажиллагаандаа бүрэн мөрдөж ажилласан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хүүхдийн төв сувиллын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжид нийцсэн байна.

Хүүхдийн төв сувилал нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Хүүхдийн төв сувиллын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хүүхдийн төв сувиллын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн “нийт хөрөнгө”-ийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 4,834,617.8 мянган төгрөгөөс тооцон 48,346.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 43,033.1 мянган төгрөгөөр тооцсон нь аудитын шалгалтаар дахин үнэлгээний үр дүнг бууруулах залруулга хийсэнтэй холбоотой болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүүхдийн төв сувиллын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,205,332.8 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, цэвэр хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	225,307.5	156,881.1	(68,426.4)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	313.5	-	(313.5)
Авлага	14,225.0	17,189.2	2,964.2
Бараа материал	210,769.0	139,691.9	(71,077.1)
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,872,666.8	4,146,426.0	2,273,759.2
Үндсэн хөрөнгө	1,872,666.8	4,146,426.0	2,273,759.2
Нийт хөрөнгийн дүн	2,097,974.3	4,303,307.1	2,205,332.8
Богино хугацаат өр төлбөр	2,491.7	2,667.9	176.2
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,095,482.6	4,300,639.2	2,205,156.6
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,097,974.3	4,303,307.1	2,205,332.8

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь тайлант жилд хүнс /ялангуяа мах/-ний материалын үнэ өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь дахин үнэлгээний үр дүнг бүртгэлд тусгаж, мөн их засвар хийж барилгын үлдэх өртөг нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд барилга байгууламж дахин үнэлгээгээр 1,854,424.9 мянган төгрөг, их засвар хийсэнтэй холбоотойгоор 212,366.0 мянган төгрөгөөр, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авснаас 183,128 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,303,307.1 мянган төгрөг болж 2,205,332.8 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хүүхдийн эмчилгээ, сувилгаа, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр 10 зорилтот бүлгийн 135 үйл ажиллагааны хөтөлбөрт зориулан 2,608,356.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,799,309.2 мянган төгрөгийг цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал болон нийгмийн даатгалын зардалд, 249,073.7 мянган төгрөгийг урсгал засварын зардалд, 229,697.3 мянган төгрөгийг эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл болон хоол хүнс, нормын хувцасны зардалд, 110,639.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмжийн зардалд, 94,815.4 мянган төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 92,303.6 мянган төгрөгийг хангамж, бараа материалын зардалд 33,518.6 мянган төгрөгийг томилолт, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрт тус тус зарцуулахаар батлагджээ. Нийт зардлын 2,606,356.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,000.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нийт санхүүжилтийн 68.9 хувийг цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал болон нийгмийн даатгалын зардлыг санхүүжүүлэхээр төсөвлөснөөс гүйцэтгэлээр 68.2 хувиар уг зардлыг санхүүжүүлж 0.7 хувийг хэмнэсэн байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,490,224.8 мянган төгрөг буюу 95.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан ба тайлант жилд 118,131.9 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан. Энэ нь үндсэн цалин хөлс Засгийн газрын тогтоолын дагуу өмнөх оны батлагдсан төсвөөс 355,710.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд байгууллагын удирдлагын зүгээс ажлын орон тоог багасган ажилласантай холбоотойгоор 91,386.0 мянган төгрөг хэмнэсэн нь голлох нөлөө үзүүлсэн.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар байгууллагаас 8,482.0 мянган, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 48,031.5 мянган, нийт 56,513.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, норматив зардалд 35,421.8 мянган, урсгал засварын зардалд 16,315.7 мянган, хангамжийн материалд 2,739.0 мянган, байрын түрээст 1,440.0 мянган, цалингийн зардалд 597.0 мянган, нийт 56,513.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 15 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд нэмж 2 эрсдэл тодорхойлж нийт 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 835,067.6 мянган төгрөгийн 9 асуудалд алдаа, зөрчил илэрснээс, 835,067.6 мянган төгрөгийн 7 асуудлын алдааг залруулж, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлэх, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 1 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Үнэлгээний хороо нь лабораторийн өрөөний засвар, гадна талбайн тохижилт хийлгэх ажлыг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1.1-д “шаардлагад нийцсэн нэг ч тендер ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзана”, 30.4-т “Бүх тендерээс

татгалзсан тохиолдолд захиалагч нь ... 30.4.1 тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний тайлангийн үр дүн, тооцоог бүртгэлд тусгахдаа үндсэн хөрөнгийг 516,467.7 мянган төгрөг, дахин үнэлгээний нэмэгдлийг 468,875.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 5,590.0 мянган төгрөгөөр илүү, элэгдлийн зардлыг 56,619.9 мянган төгрөг, хуримтлагдсан элэгдлийг 14,890.7 мянган төгрөгөөр тус тус дутуу тусгасан алдаа гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

3. Газар эзэмших эрхтэй холбоотой 234,048.0 мянган төгрөгийн дахин үнэлгээний тайлангийн үр дүнг Сангийн сайдын 2018 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 207 дугаар тушаалын Хавсралт “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ын 5.5-д “Засгийн газрын санд...” гэж заасны дагуу бүртгээгүй.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

4. Нягтлан бодогч тайлант үед ажилчдын цалинг илүү тооцсон алдаа гаргасан бөгөөд алдаагаа залруулахдаа 15,115.0 мянган төгрөгийн үндсэн цалин, хоол унааны мөнгө, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг нэмэгдэл цалингийн зардлаар бүртгэсэн, 776.6 мянган төгрөгийг буруу тооцон авлагыг илүү дүнгээр үүсгэсэн, өөрийн буруугаас шалтгаалсан 600.1 мянган төгрөгийг ажилчдаас суутган авсан. Түүнчлэн нягтлан бодогч нь аливаа залруулгыг хийхдээ холбогдох татвар, нийгмийн даатгалын тайланг залруулаагүй, өөрийн буруугаас шалтгаалсан залруулаагүй нийгмийн даатгалын шимтгэл, албан татварыг ажилчдаас суутган авсан, залруулгатай холбоотой тооцооллыг бэлтгэж анхан шатны баримтыг хавсаргаагүй байна. Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

5. Жилийн үр дүнгийн урамшууллыг 477.9 мянган төгрөгөөр илүү, 144.1 мянган төгрөгөөр дутуу тооцож олгосон бөгөөд илүү тооцож олгосонтой холбоотой 59.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг байгууллага илүү төлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

6. Тайлант жилд кассаар нийт 53,130.0 мянган төгрөгийн орлого, зарлага гарсныг санхүүгийн тайланд иж бүрэн тусгаагүй бөгөөд кассын үлдэгдлийг харилцах руу тушаах үед бүртгэлд тусгасан алдааг гаргасан нь иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

7. 15,000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг үндсэн хөрөнгийн шалгуур хангасан боловч биет бус хөрөнгийн ангид тайлагнасан алдаа нь толилуулга ба тодруулгын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

8. Өмнөх оны аудитын залруулгатай холбоотой үүссэн мөнгөн хөрөнгийн 313.5 мянган төгрөгийн эхний үлдэгдлийн дүнг тайлант жилд төрийн сан руу тушаасан боловч үл хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулсан.

Аудитаар илэрсэн 1 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Нягтлан бодогч нь цалин илүү, дутуу тооцсон алдааг залруулахдаа холбогдох татвар, нийгмийн даатгалын тайланг залруулдаггүй, өөрийн буруугаас шалтгаалсан залруулаагүй нийгмийн даатгалын шимтгэл, албан татварыг ажилчдаас суутган авдаг, залруулгатай холбоотой тооцооллыг бэлтгэдэггүй, анхан шатны баримтыг хавсаргаж холбогдох албан тушаалтны зөвшөөрлийг авдаггүй тул дараагийн аудитаар ажилчдын авлага, өглөгтэй холбоотой тооцоог зөв тооцон барагдуулж байгаа эсэх, мөн тендерийн сонгон шалгаруулалтанд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөж байгаа эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хүүхдийн төв сувилал нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд, жил, улирал, сар тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан, хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (тухай бүр), байгууллагын батлагдсан төсвийг оруулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 10,113.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 10,113.8 мянган төгрөгийг барагдуулсан, зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснээс 2 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн буюу зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүүхдийн төв сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хүүхдийн төв сувиллын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хүүхдийн төв сувиллын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Бараа материалын худалдан авалттай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

Үнэлгээний хороо нь харьцуулалтын аргаар худалдан авалт хийхдээ тендерийн жишиг бичиг баримтыг холбогдох журамд нийцүүлж бэлтгээгүй байна.

1.2. Эрсдэл:

Зах зээлийн үнээс өндөр үнээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 125 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт-д нийцүүлэн харьцуулалтын аргаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийн жишиг баримт бичгийг бэлтгэж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын зөвлөмжийг 2020 оноос эхлэн хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	225,307,518.07	156,881,093.90
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3 13,500.00	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	313,500.00	-
31110	Төгрөг	313,500.00	-
33	АВЛАГА	14,224,982.10	17,189,231.25
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	14,224,982.10	1,222,820.25
33300	Татаас санхүүжилтийн авлага	-	1,628,000.00
335	Бусад авлага	-	14,338,411.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	14,338,411.00
35	БАРАА МАТЕРИАЛ	210,769,035.97	139,691,862.65
351	Түүхий эд материал	17,300,260.08	13,171,942.94
35110	Тусгай зориулалттай материал	6,339,660.00	5,496,100.00
35130	Эм боох материал	10,960,600.08	7,675,842.94
35300	Бэлэн бүтээгдэхүүн	135,200,495.15	99,367,950.00
354	Хангамжийн материал	58,268,280.74	27,151,969.71
35410	Бичиг хэргийн материал	148,950.23	146,210.00
35420	Аж ахуйн материал	122,000.00	1,732,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,100,000.00	-
35440	Түлш шатах тослох материал	-	1,990,000.00
35450	Барилгын засварын материал	15,508.05	1,510,300.00
35460	Хүнсний материал	10,844,900.28	4,542,375.51
35470	Бусад хангамжийн материал	44,036,922.18	17,230,584.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,872,666,762.10	4,146,425,981.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,872,666,762.10	4,146,425,981.40
392	Биет хөрөнгө	1,872,666,762.10	3,912,377,981.40
39201	Барилга, байгууламж	2,779,041,618.49	3,700,057,885.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,189,306,223.46)	(155,681,164.00)
39203	Авто тээврийн хэрэгсэл	66,500,000.00	136,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(59,395,833.28)	(97,999,999.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	539,302,032.38	583,643,867.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	(346,702,675.55)	(385,741,883.86)
39211	Батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмж	365,779,400.67	441,967,120.67
39212	Хуримтлагдсан элэгдэл	(282,551,557.15)	(310,367,844.64)
393	Биет бус хөрөнгө	-	234,048,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	36,048,080.00	255,096,080.00
39304	Хасагдуулга	(36,048,080.00)	(21,048,080.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,097,974,280.17	4,303,307,075.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,491,725.81	2,667,886.53
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,491,725.81	2,667,886.53
413	Өглөг	2,491,725.81	2,667,886.53
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	783,783.57	0.58

Хүүхдийн төв сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

4136	Бусад өглөг	1,707,942.24	2,667,885.95
41361	Байгууллагад төлөх өглөг	470.00	1,633,321.00
41362	Хувь хүмүст төлөх өглөг	1,707,472.24	1,034,564.95
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,095,482,554.36	4,300,639,188.77
51	Засгийн газрын хувь оролцоо	2,095,482,554.36	4,300,639,188.77
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	714,392,294.00	948,440,294.00
51101	Өмч: -Төрийн өмч	714,392,294.00	948,440,294.00
512	Хуримтлагдсан үр дүн	715,435,174.77	832,118,919.22
51210	Өмнөх үеийн үр дүн	715,435,174.77	715,845,445.92
51220	Тайлант үеийн үр дүн	-	116,273,473.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	665,655,085.59	2,520,079,975.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,097,974,280.17	4,303,307,075.30

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,188,228,772.00	2,910,382,466.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	122,121,230.00	247,512,166.44
120	Нийтлэг татварын бус орлого	122,121,230.00	247,512,166.44
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	122,121,230.00	247,512,166.44
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,065,500.00	5,107,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	103,055,730.00	242,404,666.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,066,107,542.00	2,662,870,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,945,103,500.00	2,606,356,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,945,103,500.00	2,606,356,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,004,042.00	56,513,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	114,254,042.00	8,482,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,750,000.00	48,031,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,226,477,434.41	2,794,108,993.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,226,477,434.41	2,794,108,993.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,137,365,863.01	2,558,284,293.54
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,251,983,823.49	1,507,025,745.91
210101	Цалин	783,350,776.59	949,406,218.23
210102	Нэмэгдэл цалин	342,623,499.90	273,086,919.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,828,126.00	117,131,652.00
210104	Урамшуулал	72,181,421.00	167,400,955.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,776,760.74	185,992,108.76
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	102,723,810.27	128,083,560.77
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	12,769,750.04	15,280,693.62
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	10,085,240.03	12,078,633.84
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,362,348.18	2,761,483.76
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	23,835,612.22	27,787,736.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,465,475.30	81,804,231.10
210301	Гэрэл цахилгааны зардал	33,431,919.00	35,421,717.30
210302	Түлш, халаалтын зардал	30,220,355.90	30,626,139.18
210303	Цэвэр, бохир усны зардал	16,813,200.40	14,316,374.62
210304	Байрны түрээс	-	1,440,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	123,955,748.86	129,489,624.12
210401	Бичиг хэргийн материал	6,124,813.93	9,600,120.23
210402	Тээвэр, шатахууны зардал	6,281,150.00	11,778,300.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	1,679,299.94	1,628,941.42
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	4,847,900.00	12,839,920.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	55,717,314.46	74,692,077.98
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	9,787,601.00	5,038,840.00
210408	Бараа материал актасны зардал	39,517,669.53	13,911,424.49
2105	Нормативт зардал	263,659,561.00	388,149,968.80
210501	Эм	77,104,187.59	85,707,858.37
210502	Хоол	186,555,373.41	223,265,489.77
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	79,176,620.66
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,698,626.95	37,110,354.74
210601	Багаж хэрэгсэл	534,000.00	15,406,000.00
210602	Тавилга	-	430,796.69
210604	Урсгал засвар	12,164,626.95	21,273,558.05
2107	Томиллолт, зочны зардал	2,343,800.00	939,100.00
210702	Дотоод томиллолтын зардал	2,343,800.00	939,100.00

Хүүхдийн төв сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	19,832,400.00	20,913,770.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,000,000.00	12,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	314,800.00	314,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,200.00	485,170.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,500,000.00	333,200.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	3,097,900.00	5,680,300.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	247,500.00	100,300.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	487,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	230,649,666.67	206,859,390.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,716,340.00	9,462,050.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,675,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	218,258,326.67	197,397,340.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,111,571.40	235,824,699.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,578,130.00	109,711,230.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,888,130.00	107,461,230.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	2,190,000.00	2,250,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,533,441.40	126,113,469.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,533,441.40	126,113,469.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(38,248,662.41)	116,273,473.30
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(38,248,662.41)	116,273,473.30

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,085,173,042.00	2,674,166,327.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,065,500.00	9,668,027.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,065,500.00	9,668,027.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	19,065,500.00	9,668,027.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,065,500.00	9,668,027.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,066,107,542.00	2,664,498,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,945,103,500.00	2,606,356,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,945,103,500.00	2,606,356,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,004,042.00	58,141,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	114,254,042.00	8,482,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,750,000.00	49,659,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,005,173,727.00	2,444,857,935.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,005,173,727.00	2,207,405,235.40
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,916,062,155.60	2,207,405,235.40
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,269,351,344.39	1,508,596,887.46
210101	Үндсэн цалин	801,600,660.94	928,566,269.85
210102	Нэмэгдэл	309,451,396.31	370,274,304.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	91,162,788.06	120,988,700.04
210104	Үр дүнгийн урамшуулал	67,136,499.08	88,767,613.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,552,973.87	191,136,015.82
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	126,983,944.19	127,160,515.82
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	12,436,800.00	15,993,900.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	6,481,364.00	12,795,100.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,487,400.00	3,198,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,163,465.68	31,987,700.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	81,117,975.30	81,804,231.10
210301	Гэрэл цахилгааны зардал	33,653,419.00	35,421,717.30
210302	Түлш, халаалтын зардал	30,220,355.90	30,626,139.18
210303	Цэвэр, бохир усны зардал	17,244,200.40	14,316,374.62
210304	Байрны түрээс	-	1,440,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	97,187,671.54	95,039,441.42
210401	Бичиг хэрэг	3,998,010.00	3,285,900.00
210402	Тээвэр, шатахуун	6,281,150.00	13,768,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,679,299.94	1,676,141.42
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,847,900.00	14,221,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	76,381,311.60	62,087,500.00
2105	Нормативт зардал	278,499,905.50	265,113,359.60
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,281,624.00	55,072,099.60
210502	Хоол, хүнс	143,861,831.50	168,741,260.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	74,356,450.00	41,300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,987,585.00	35,755,150.00
210601	Багаж техник хэрэгсэл	11,738,160.00	2,202,500.00
210602	Тавилга	-	3,640,000.00
210604	Урсгал засвар	3,249,425.00	29,912,650.00
2107	Томиллолт, зочны зардал	2,413,800.00	939,100.00
210702	Дотоод албан томиллолт	2,413,800.00	939,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,275,900.00	29,021,050.00

Хүүхдийн төв сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	12,000,000.00	12,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	314,800.00	314,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,200.00	485,170.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,500,000.00	1,499,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,097,900.00	7,621,800.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	247,500.00	100,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,930,500.00	4,999,880.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,675,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,675,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,111,571.40	237,452,699.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,578,130.00	109,711,230.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,888,130.00	107,461,230.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	2,190,000.00	2,250,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,533,441.40	127,741,469.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,533,441.40	127,741,469.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	79,999,315.00	229,308,392.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	79,686,115.00	229,621,892.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	79,686,115.00	229,621,892.00
2200	Дотоод эх үүсвэрээр	79,686,115.00	229,621,892.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	79,686,115.00	229,621,892.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(79,686,115.00)	(229,621,892.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	313,200.00	(313,500.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	300.00	313,500.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	313,500.00	0.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
ДАНС	511	51300	51210+51220	
2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	714,392,294.00	665,787,161.09	860,376,187.69	2,240,555,642.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(106,692,350.51)	(106,692,350.51)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	714,392,294.00	665,787,161.09	753,683,837.18	2,133,863,292.27
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(38,248,662.41)	(38,248,662.41)
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	714,392,294.00	665,655,085.59	715,435,174.77	2,095,482,554.36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	410,271.15	410,271.15
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	714,392,294.00	665,655,085.59	715,845,445.92	2,095,892,825.51
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	1,854,424,889.96	-	1,854,424,889.96
Өмчид гарсан өөрчлөлт	234,048,000.00		-	234,048,000.00
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	116,273,473.30	116,273,473.30
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	948,440,294.00	2,520,079,975.55	832,118,919.22	4,300,639,188.77

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/төгрөгөөр/			
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,608,356,800.00	2,490,224,857.40	118,131,942.60	95.47
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,608,356,800.00	2,490,224,857.40	118,131,942.60	95.47
Бараа, үйлчилгээний зардал	2,497,717,800.00	2,380,513,627.40	117,204,172.60	95.31
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,599,385,900.00	1,507,999,887.46	91,386,012.54	94.29
Үндсэн цалин	940,207,000.00	927,969,269.85	12,237,730.15	98.70
Нэмэгдэл	423,093,200.00	370,274,304.57	52,818,895.43	87.52
Унаа, болон бусад нөхөн олговор	142,065,000.00	120,988,700.04	21,076,299.96	85.16
Урамшуулал	94,020,700.00	88,767,613.00	5,253,087.00	94.41
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	199,923,300.00	191,136,015.82	8,787,284.18	95.60
Тэтгэврийн даатгал	135,947,800.00	127,160,515.82	8,787,284.18	93.54
Тэтгэмжийн даатгал	15,993,900.00	15,993,900.00	-	100.00
ҮОМШӨ ний даатгал	12,795,100.00	12,795,100.00	-	100.00
Ажилгүйдлийн даатгал	3,198,800.00	3,198,800.00	-	100.00
Эрүүл мэндийн даатгал	31,987,700.00	31,987,700.00	-	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,815,400.00	80,364,231.10	14,451,168.90	84.76
Гэрэл цахилгаан	36,957,900.00	35,421,717.30	1,536,182.70	95.84
Түлш, халаалт	36,275,500.00	30,626,139.18	5,649,360.82	84.43
Цэвэр, бохир ус	21,582,000.00	14,316,374.62	7,265,625.38	66.33
Хангамж, бараа материалын зардал	92,303,600.00	92,300,441.42	3,158.58	100.00
Бичиг хэрэг	2,665,900.00	2,665,900.00	-	100.00
Тээвэр (шатахуун)	13,768,300.00	13,768,300.00	-	100.00
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,679,300.00	1,676,141.42	3,158.58	99.81
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,221,600.00	14,221,600.00	-	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	59,968,500.00	59,968,500.00	-	100.00
Нормативт зардал	229,697,300.00	229,691,559.60	5,740.40	100.00
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,572,100.00	51,572,099.60	0.40	100.00
Хоол, хүнс	138,825,200.00	138,819,460.00	5,740.00	100.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	39,300,000.00	39,300,000.00	-	100.00
Эд хогшил худалдан авах	249,073,700.00	249,061,342.00	12,358.00	100.00
Багаж, техник, хэрэгсэл	10,707,700.00	10,707,700.00	-	100.00
Тавилга	10,000,000.00	9,990,000.00	10,000.00	99.90
Урсгал засвар	228,366,000.00	228,363,642.00	2,358.00	100.00
Томилолт, зочны зардал	2,413,800.00	939,100.00	1,474,700.00	38.91
Дотоод албан томилолт	2,413,800.00	939,100.00	1,474,700.00	38.91
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	30,104,800.00	29,021,050.00	1,083,750.00	96.40
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,000,000.00	12,000,000.00	-	100.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,200,000.00	2,000,000.00	200,000.00	90.91
Даатгалын үйлчилгээ	314,800.00	314,800.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	485,170.00	14,830.00	97.03
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,500,000.00	1,499,100.00	900.00	99.94

Хүүхдийн төв сувиллын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мэдээллийн технологийн зардал	8,000,000.00	7,621,800.00	378,200.00	95.27
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	590,000.00	100,300.00	489,700.00	17.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,000,000.00	4,999,880.00	120.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,639,000.00	109,711,230.00	927,770.00	99.16
Бусад урсгал шилжүүлэг	110,639,000.00	109,711,230.00	927,770.00	99.16
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	108,199,000.00	107,461,230.00	737,770.00	99.32
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,440,000.00	2,250,000.00	190,000.00	92.21
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,000,000.00	2,489,911,357.40	118,445,442.60	95.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,608,356,800.00	2,480,243,330.40	126,113,469.60	95.2
Улсын төсвөөс санхүүжих	2,608,356,800.00	2,480,243,330.40	126,113,469.60	95.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	9,668,027.00	(7,668,027.00)	483.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	9,668,027.00	(7,668,027.00)	483.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	313,500.00	(313,500.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	123	113	10	91.9
Удирдах ажилтан	6	5	1	83.3
Гүйцэтгэх ажилтан	70	61	9	87.1
Үйлчлэх ажилтан	47	47	-	100
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

Төсвийн тохируулга

Үзүүлэлт	Төсвийн тохируулга
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	127,741,469.60
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	127,741,469.60
Улсын төвлөрсөн төсвөөс	126,113,469.60
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	126,113,469.60
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,628,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,628,000.00
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	127,741,469.60
УРСГАЛ ЗАРДАЛ	127,741,469.60
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,741,469.60
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	127,741,469.60
Төвлөрүүлэх шилжүүлэг	127,741,469.60

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	56,513,500.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	56,513,500.00
Бараа, үйлчилгээний зардал	-	56,513,500.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	597,000.00
Үндсэн цалин	-	597,000.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	1,440,000.00
Байрны түрээс	-	1,440,000.00
Хангамж, бараа материалын зардал	-	2,739,000.00
Бичиг хэрэг	-	620,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	-	2,119,000.00
Нормативт зардал	-	35,421,800.00
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	3,500,000.00
Хоол, хүнс	-	29,921,800.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	-	2,000,000.00
Эд хогшил худалдан авах	-	16,315,700.00
Багаж, техник, хэрэгсэл	-	2,400,700.00
Урсгал засвар	-	13,915,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	56,513,500.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	56,513,500.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	8,482,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	48,031,500.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	123	113
Удирдах ажилтан	6	5
Гүйцэтгэх ажилтан	70	61
Үйлчлэх ажилтан	47	47
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-
ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.02.21	Аудитын нэр:	Хүүхдийн төв сувиллын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020/127/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Хүүхдийн төв сувилал		мянган төгрөгөөр	

№	Аудитын чиглэл	Тоо	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	Балансын данстай холбоотой асуудал	1	Үнэлгээний хороо нь лабораторийн өрөөний засвар, гадна талбайн тохижилт хийлгэх ажлыг сонгон шалгаруулахдаа "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 30.1.1, 30.4.1 дүгээр заалтыг мөрдөж ажиллаагүй байна.	-	Албан шаардлага өгсөн	2020.02.20	1	Захирал Тендерийн үнэлгээний хорооны дарга	Д.Оюунцэцэг Т.Баярцэцэг
2	Балансын данстай холбоотой асуудал	1	Үнэлгээний хороо нь харьцуулалтын аргаар худалдан авалт хийхдээ тендерийн жишиг бичиг баримтыг холбогдох журамд нийцүүлж бэлтгээгүй байна.	-	Зөвлөмж өгөгдсөн	2020.02.20	2	Захирал Тендерийн үнэлгээний хорооны дарга	Д.Оюунцэцэг Д.Бурмаа
			Дүн	-					



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 03

№ 02/72

Улаанбаатар хот

СЭГ- 2020/127/СТА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хүүхдийн төв сувиллын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороо нь лабораторийн өрөөний засвар, гадна талбайн тохижилт хийлгэх ажлыг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 30.1.1-д “шаардлагад нийцсэн нэг ч тендер ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзана”, 30.4-т “Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч нь ... 30.4.1 тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах”, 34.1-д “Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах,
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 04 дүгээр сарын 30-ны дотор албан ёсоор ирүүлэхийг захирал Д.Оюунцэцэг, тендерийн үнэлгээний хорооны дарга Т.Баярцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

Ж.БОЛОРМАА

ХҮЛЭГТХҮННҮ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.АЛТАНЗУЛ

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ

Д.ОЮУНЦЭЦЭГ

ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ

ХОРООНЫ ДАРГА

Т.БАЯРЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

